

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 12 2022 оны 10-р сар

■ ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”

Салхитын ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн талаар иргэдэд мэдээлэл өгөх “Нээлттэй хаалганы өдөрлөг” Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвд 2022 оны 9 сарын 28, 29-ний өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Тус арга хэмжээг MERIT төсөл, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК болон Дундговь аймгийн ЗДТГ, Гурвансайхан сумын захиргаатай хамтран зохион байгуулав. Өдөрлөгт давхардсан тоогоор 560 гаруй иргэн, малчид, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид оролцож уурхайн хаалтын талаар мэдээлэл авч, санал хүсэлтээ уламжлав. Арга хэмжээний үеэр эмэгтэйчүүд, бизнес эрхлэгчид, нөлөөлөлд өртөж буй Чулуут багийн иргэд, төрийн албан хаагчид зэрэг 4 бүлгийн хэлэлцүүлэг тусгайлан өрнүүлж, оролцогч талууд Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөтэй холбоотой санал бодлоо нээлттэй илэрхийлж ярилцлаа.

“Нээлттэй хаалганы өдөрлөг” хоёр өдрийн арга хэмжээний туршид хаалтын төлөвлөгөө боловсруулж буй үндэсний зөвлөхүүд өөрсдийн гүйцэтгэж буй ажил үүрэг, түүний ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгч, сонирхсон асуултад хариулж, нээлттэй яриа өрнүүлэв. Иргэд байгаль орчин ба нөхөн сэргээлт, усны нөөц ба менежмент, нийгэм-эдийн засаг ба жендэр, хаалтын өртөг зардал тооцоолох, хууль эрх зүй, уур амьсгалын өөрчлөлт зэрэг үндэсний зөвлөхүүдийн болон “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, MERIT төслийн өртөөгөөр зочилж, уурхайн хаалтын талаар цогц ойлголт, мэдээлэл авлаа. Өдөрлөгт оролцсон иргэд “Уг арга хэмжээнд оролцсоноор уурхайн хаалт гэдэг нь одоо хаах тухай биш 10 жилийн дараах хаалтыг одоо төлөвлөх тухай ярьж байгааг ойлгож авлаа”, “Уурхай хаалттай байсан, одоо нээлттэй болно гэж байгаад баяртай байна” хэмээн сэтгэгдлээ хуваалцав.



Зураг 1. Гурвансайхан сумын төвд болсон иргэдэд мэдээлэл өгөх нээлттэй хаалганы өдөрлөг



Зураг 2. Иргэд үндэсний зөвлөхүүдийн өртөөгөөр зочилж, уурхайн хаалтын талаар мэдээлэл авч, санал бодлоо хуваалцав.


Салхитын уурхайн хаалтын төлөвлөлттэй холбоотой санал хүсэлтээ бүлгийн хэлэлцүүлэгт оролцох, төлөвлөлтийн багийн зөвлөхүүдтэй уулзаж ярилцах, саналын хуудас бөглөх зэргээр өгсөн болно. Уурхайн хаалттай холбоотой иргэдээс ирсэн саналыг жагсааж, графикаар харуулав (Зураг 3-ыг харна уу).

Нөхөн сэргээлт: Нутгийн ургамлыг тарьж, бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжит байдлаар нөхөн сэргээх.

Дэд бүтэц: Уурхай хаасны дараа эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан Чулуут багийг жишиг багийн төв болгон хөгжүүлэх, уурхайн дэд бүтцийг түшиглэн жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, үүрэн телефоны сүлжээг сайжруулах, уурхайн хаалтыг сум орон нутагт үр өгөөжтэй байхаар төлөвлөж хэрэгжүүлэх, сум уурхайг холбосон засмал зам тавих.

Усны нөөц: Усны нөөцийн зохистой менежментийг хэрэгжүүлж, усны нөөцийг нөхөн сэргээж, түвшинг нэмэгдүүлэхэд анхаарах.

Зураг 3. Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр иргэдийн бөглөсөн саналын хуудасны нэгтгэсэн дүн.



ТӨСЛИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭЭЛЖИТ УУЛЗАЛТ

Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн II үе шатны хэрэгжилтийн явц, иргэдэд мэдээлэл өгөх “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн ач холбогдол, үр дүнг танилцуулах, санал солилцох уулзалтыг 2022 оны 10 сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтын үеэр Салхитын уурхайн нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдлын суурь судалгааны үр дүнг мөн танилцуулав.

Зөвлөлдөх уулзалтад “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, MERIT төслийн баг, олон улсын зөвлөхүүд (Канад улсын байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Си Пи Пи Энвайронментал” корпораци), үндэсний зөвлөхүүдээс бүрдсэн төлөвлөлтийн баг, УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, Усны газар, МХЕГ, Mining Journal, Дундговь аймгийн ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, МХГ, Гурвансайхан сумын ЗДТГ, ИХТ зэрэг төлөөлөл оролцлоо.

Оролцогч талууд уурхайн нөлөөлөлд өртөж буй иргэдийг мэдлэг, мэдээллээр хангах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, орон нутгийн дэмжлэгийг авах ач холбогдлыг өндрөөр үнэлж, цаашид жишиг төслийн энэхүү туршлагыг бусад компани болон орон нутагт түгээн дэлгэрүүлэх шаардлагатайг онцолж байв.

ГАЗАР ХЭЛБЭРШҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

10-р сард газар хэлбэршүүлэлтийн баг буюу төлөвлөлтийн баг гурван удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, газар хэлбэршүүлэлтийн зураг төслийн шалгуур үзүүлэлтүүдийн талаар ярилцаж санал нэгдэв. Эдгээр шалгуур үзүүлэлт нь хаалтын зорилтуудад нийцсэн ландшафтыг байгуулахад чухал ач холбогдолтой. Шалгуур үзүүлэлтүүдийг дор жагсаав.

- Хэлбэршүүлэлтийн налуу тодорхойлох
- Шимт хөрс хучилтын зузаан
- Хэлбэршүүлэлтийн тусгаарлах хучилтын зузаан (хэр хэмжээний чулуулгийн овоолгыг хаягдлын сангийн хучилтад ашиглах)
- Уурхайн талбайн хэмжээнд нөхөн сэргээлтэд ашиглаж болох материалын жагсаалт, эзлэхүүн (үүнд хаягдал чулуулаг, шимт хөрс багтана)
- Нөхөн сэргээлтэд ашиглах материалуудын оновчлол (шимт хөрсний хэмжээ, нөхөн сэргээлтэд шаардагдах шимт хөрсний хэмжээ)
- Гадаргын усны менежмент (ирмэгийн налуу болон урт)
- Ил уурхайн ухшад үүсэх нуурын үзүүлэлтүүд
- Нөхөн сэргээлтийн стандартууд (Монгол улсын стандарт шаардлагад нийцсэн байх)

Мөн газар хэлбэршүүлэлтийн багийн ахлагч уурхайн хаягдал чулуулгийн овоолго болон ил ухшын ерөнхий төсөөлөл зургийг танилцуулав. Төлөвлөлтийн багийн гишүүд газар хэлбэршүүлэлтийн багийн боловсруулсан дээрх зураг төслийн талаар хэлэлцэж, хэрхэн сайжруулах талаар санал бодлоо хуваалцав.

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ

- 10-р сарын 19-нд усны менежментийн чадавх бэхжүүлэх 3 цагийн сургалт зохион байгуулав. Оролцогчид уурхайн хаалтын асуудалд уурхайн ашиглалтын үеийн усны нөөцийн бохирдлын эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхийн ач холбогдлын талаар ойлголт авлаа. Мөн гадаргын болон гүний усны нөөцийн хаалтын дараах хяналт-шинжилгээ, үйл ажиллагааг бүрэн зогсоох шаардлагуудын талаар хэлэлцэв.
- 10-р сарын 21, 27-ны өдрүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулж, уур амьсгалын түүхэн чиг хандлага, Монгол орны төв хээрийн бүсийн нөхөн сэргээлтийн ажилд учруулж болзошгүй уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг танилцуулав. Төлөвлөлтийн баг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуйц нөхөн сэргээлтийн төлөвлөлт хийх аргачлалыг тодорхойлох юм.

11-Р САРД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД:

- 2022 оны 11-р сарын 03, 04, 10, 16: Төлөвлөлтийн баг газар хэлбэршүүлэлтийн зураг төслийг эцэслэн боловсруулна.
- 11-р сарын 01, 08: “Хаалтын дараах хяналт-шинжилгээ, мониторинг” чадавх бэхжүүлэх сургалт
- 11-р сарын 15: “Дасан зохицох менежмент” чадавх бэхжүүлэх сургалт

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал

Р.Алтангэрэлтэй имэйл хаягаар холбогдоно уу.

r.altangerel@merit.mn